



 БАТЛАВ
 УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН
 ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХТЭГЭЭН
 ДАРГА  Д.ЦОГТБААТАР

2019 оны 11 дугаар сарын 20

**ПРОКУРОРЫН АЖИЛ, АМЬДРАЛЫН ОНЦЛОГИЙГ
ХАРУУЛСАН ОЛОН АНГИТ УРАН САЙХНЫ
КИНОНЫ АЖЛЫН ДААЛГАВАР**

2019 оны 11 дүгээр сарын 20

Улаанбаатар хот

1	Захиалагч	Улсын Ерөнхий прокурорын газар
2	Олон ангит уран сайхны кино хийлгэх үндэслэл	Монгол Улсад Прокурорын байгууллага байгуулагдсаны 90 жилийн ойг тэмдэглэх бэлтгэл Ажлын төлөвлөгөөний 2.3-т "Прокурорын ажил, амьдралын онцлогийг харуулсан олон ангит уран сайхны кино хийлгэх" гэж заасныг хэрэгжүүлэх
3	Киноны ач холбогдол, үр дүн	Иргэд, олон нийтэд Прокурорын байгууллагын үйл ажиллагаа, прокурорын ажлын талаар бодит, эерэг ойлголт өгч, итгэх итгэлийг нэмэгдүүлэх, прокурор, ажилтнуудад ажлын урам зориг өгөх
4	Кино зохиолд тусгагдсан байх санаа, гүйцэтгэлд тавигдах шаардлага	<ol style="list-style-type: none"> 1. Прокурорын байгууллагын түүх, чиг үүрэг, үйл ажиллагааны онцлогийг судлан тусгах 2. Прокурорын ажил, амьдралтай биечлэн танилцаж, бодит төсөөлөл авсан байх 3. 8-10 анги бүхий кино зохиолыг бүрэн бичсэн байх 4. Анги тус бүр 40 минутаас доошгүй үргэлжилсэн байх 5. Нийгэмд өгөх эерэг мессэжид зохиолын агуулга чиглэгдсэн байх 6. Кино зураг авалт хийх, монтажлах, дуу дүрсний тохируулга хийх, дэлгэцэнд гаргах зэрэг цаг хугацааны хуваарийг нэгбүрчлэн гаргасан байх 7. Кино гаргах телевизтэй гэрээ байгуулсан байх 8. Киног олон нийтэд хүргэсний дараа хүрэх үр дүнгийн талаарх урьдчилсан төсөөлөл, тайлан
5	Кино хийх этгээдэд	1. Кино хийх мэргэжлийн багтай байх

	тавигдах шаардлага	<ol style="list-style-type: none"> 2. Прокурорын ажил, амьдралыг сайтар мэддэг зөвлөхтэй байх 3. Мэргэжлийн зохиолч, найруулагч, жүжигчинтэй байх 4. Зураг авалт хийх, монтажлах зэрэг тоног төхөөрөмж, студитай байх 5. Компанийн үйл ажиллагааны зөвшөөрөлтэй байх 6. Энэ чиглэлээр 3-аас доошгүй жил үйл ажиллагаа явуулсан байх 7. Олны хүртээл болж, нийтэд танигдсан бүтээл хийсэн байх 8. Татварын болон шүүхийн шийдвэрээр тогтоогдсон бусдад төлөх өр төлбөргүй байх
6	Кино багийн эдийн засгийн тооцоо, төсөв	<ol style="list-style-type: none"> 1. Тендерийн төсөвт өртөг 200.0 /хоёр зуун сая/ төгрөг 2. Киноноос олох ашиг орлогын тооцоог хийсэн байх
7	Кино төслийн гүйцэтгэх хугацаа	2020 оны 08 дугаар сарын 14-нд киноны нээлтийг хийж, олон нийтэд хүргэх

--- оОо ---